

ДеФакто **ТОЙМ**

➤ АВЛИГЫН
НЭГ ХЭРЭГ
ШИЙДЭГДЭВ,
БУСАД НЬ?

➤ “ИРЭЭДҮЙН
ӨВ САН
КОРПОРАЦИ” ХХК
БАЙГУУЛАВ

XI НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

БАЙГАЛИЙН БАЯЛАГ ЯГ ХЭНИЙ ӨМЧ ВЭ?

II НҮҮРТ



ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ

Ц.Батболд

Хөгжлийн эдийн засагч (PhD), олон улсын хуульч
бөгөөд АНУ-д мэргэжлээрээ ажиллаж байна.

ҮНДСЭН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ
юунд төвлөрөх хэрэгтэй вэ?

VIII НҮҮРТ



НИЙТЛЭЛ

Дэлгэрийн Уянга
Өмгөөлөгч, хууль зүйн доктор

**НЭГ УЛС, НЭГ ТОЙРОГ БА
ГАДААД ДАХЬ МОНГОЛЧУУД**

IV НҮҮРТ



НИЙТЛЭЛ

Ц.Баасансүрэн
Сэтгүүлч

МОСКВА, ХОНГКОНГИЙН
эмзээглэл маньд хамаатайн учир

VI НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА


| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.08.01, №4 (108)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

БАЙГАЛИЙН БАЯЛАГ ЯГ ХЭНИЙ ӨМЧ ВЭ?





Дамбадаржаагийн ЖАРГАЛСАЙХАН

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

БАЙГАЛИЙН БАЯЛАГ ЯГ ХЭНИЙ ӨМЧ ВЭ?

Монголчууд үндсэн хуулиндаа нэмэлт өөрчлөлт оруулахаар төр, хувийн хэвшил, иргэний нийгмийг хамруулсан олон талын хэлэлцүүлэг өрнүүлж байна. УИХ-д олонх суудалтай МАН-ын төсөл ба Ерөнхийлөгчийн төслийг нэгтгэхийн тулд зөвшилцөх ажлын хэсэг байгуулагдсан. Тэр дундаа газар болон байгалийн баялаг яг хэний өмч болох тухай хэлэлцсэн нь үндсэн хуулиасаа ч том асуудал сөхөж орхив. Энэ чухал асуудал монголд тодорхой биш явж ирсэн нь одоо л нэг ил гарч, нийтээр хэлэлцэх боломж анх удаа нээгдлээ. Нэгэнт л сөхсөн учир бүрхэг, холимог явж ирсэн өмчийн болон төр засгийн ойлголтоо нэг мөр цэгцлэн нэр томъёоллыг нь засчихвал зүгээр.

ЗАРЧМЫН ЯЛГАА

Одоогийн Үндсэн хуулийн 6.1-д “Монгол улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”. 6.2-д “Монгол улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэж заасан.

- Тэгвэл УИХ-аас 6.2 дээр “Төрөөс байгалийн баялагийг ашиглахдаа тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах зарчмыг баримтална” гэсэн нэмэлт оруулах санал гаргалаа.
- Харин Ерөнхийлөгч “Монгол улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан нь нийтийн өмч мөн. Байгалийн баялагийг ашиглахдаа тэгш байдал, шударга ёс, үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах зарчим баримтална” гэсэн нэмэлт оруулав.

Нэг нь байгалийн баялаг бол төрийн, нөгөө нь үгүй ээ, нийтийн өмч гэсэн ялгаатай саналууд. Энэ бол зарчмын ялгаа бөгөөд үүнийг яаж шийдвэрлэхээс хамааран ганц үндсэн хууль төдийгүй бусад хуулиудад өөрчлөлт оруулах шаардлага тулгарна.

ОЙЛГОЛТЫН ЯЛГАА

Монголд ардчилсан улс орны төр болон засаг гэсэн нэр томъёог ойлголгүй хуулиндаа буруу тусган хэрэглэж ирсэн. Төр (state) бол өөрчлөгддөггүй улс төрийн нэгж, харин засаг (government) нь ардчилсан чөлөөт сонгуулиар өөрчлөгддөг. Төрийг сонгогдсон засаг нь удирддаг. Засаг нь харилцан тэнцвэртэй, хяналттай гурван засаглалаас бүрддэг. Үүнд хууль тогтоох, хуулийг хэрэгжүүлэх, шүүх засаглал ордог.

Монголд хаант засгийн үеэсээ гүйцэтгэх засгаа дангаар нь Засгийн газар гэж нэрлэж иржээ. Одоогийн ҮХ-д Засгийн газрыг “төрийн гүйцэтгэх дээд байгууллага” гэж зөв тодорхойлсон ч, ташаа нэрлэжээ. Засгийн газрыг Сайд нарын Зөвлөл эсвэл Танхим (Cabinet) гэж товч нэрлэх нь оновчтой. ►►

- Мөн ардчилсан орны засаг нь бүх иргэдийн дийлэнхийн саналаар сонгогддог учир олон хүмүүсийн буюу улсын засаг. Монголчууд олон хүнийг улс гэж хэлдэг. Гэтэл нөгөөх нийтийн өмч ба хөрөнгө гэдэг нь бүх хүний гэх эзэнгүй ойлголт юм. Тийм учраас газар, газрын хэвлий, байгалийн баялагийг төрийн биш улсын өмч гэж тусгах нь илүү зохистой. Улсын буюу бүх монголчуудын өмчийг тодорхой хууль журмын дагуу төр, засаг нь захиран зарцуулах эрхтэй. Нэгэнт л хүн бүрийн саналыг асуулт бүрээр авах боломжгүй учраас, дийлэнхийн саналыг авч байгуулсан ардчилсан засагт тийм эрхийг өгөхөөс өөр сонголтгүй. Ардчилал нь бусад засаглалаас үүгээрээ ялгаатай.

ӨМЧИЙН ХЭЛБЭР

Улсын өмчийг төр, засаг яаж захиран, зарцуулах тухай хууль журам батлах шаардлагатай болно. Дэлхийн олон оронд газрын болон түүний баялагийн өмчлөлийг зөв шударга зохицуулах түүхэн боломж олдоогүй юм. Жишээ нь эдүгээ Английн газар нутгийн талыг хүн амын 1 хувь эзэмшдэг болохыг Guardian сонин нийтэлсэн. АНУ-ын ихэнх мужийн газар нутгийн талыг нь Холбооны Засгийн газар эзэмшиж байна. Олон оронд төр засаг өөрөө юу ч бүтээгээгүй, бүтээдэггүй учир төрийг өмчтэй байхыг эсэргүүцдэг. Тийм ч учраас байгалийн баялагийг Public (people's) буюу улсын өмч гэж үзэж, ашигласны төлбөрийг төр, засаг нь аваад улсын хэрэгцээнд үр ашигтай зарцуулж, хойч үеийнхэндээ үлдээхийг зорьдог.

Байгалийн баялагийг ҮХ-даа Хятад, Казахстан, Өмнөд Солонгос, Катар, Саудын Араб гэх мэт оронд төрийн өмч гэж заасан бол АНУ, Австрали, Канад, Швед, Финланд, Шинэ Зеланд, Австри, Франц, Энэтхэг, Сингапур, Япон орнуудад хэн нэгэн өмчлөх тухай огт заагаагүй байна.

Иймд бид ҮХ-даа иргэдийн болон нийтийн өмч гэхийн оронд хувийн (хувь хүн, хуулийн этгээдийн), хамтын (тодорхой байршилд оршин суугаа бүлэг хүмүүсийн), улсын (монголын бүх иргэдийн) өмч гэвэл олон улсын жишигт нийцнэ.

ҮХ-д оруулж буй энэ удаагийн өөрчлөлт нь өнөөгийн улс төрчдийн хоорондын өрсөлдөөн, тэрсэлдээний болон эрх мэдлээ баталгаажуулах хэрэгсэл байж болохгүй. Энэ нэмэлт өөрчлөлт нь эдийн засгийн хөгжлийн суурь болсон бүх төрлийн өмчийг эзэнтэй болгоход чиглэх ёстой. Хэрэв төр, засаг түүний бүтцийг зөв нэрлэн, байгалийн баялагийг төрийн биш улсын өмч болох, энэ өмчийг засаг нь тодорхой хуулийн дагуу захиран зарцуулах ёстойг ойлгомжтой болгож чадвал монголчууд энэ удаа ҮХ-даа шаардлагатай нэмэлт өөрчлөлтөө хийж, алдаагаа засч чадах болно.

2019.07.31




The Defacto Gazette

НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916



Дэлгэрийн Уянга
Өмгөөлөгч, хууль зүйн доктор

НИЙТЛЭЛ



НЭГ УЛС, НЭГ ТОЙРОГ БА

ГАДААД ДАХЬ МОНГОЛЧУУД

Монголын улс төр сошиал медиад явагддаг болсноос хойш гадаад дахь монголчууд Монгол Улс доторх олон түмний үзэл санаа бүрэлдэн тогтоход нөлөөлөх нэгэн хүч болсон. Хамгийн олон найз, дагагчтай нүүрномчид, жиргээчид гадаадад байх нь нийтлэг. Үүний үр дүнд Засгийн газар болон улс төрийн намууд нь зөвхөн Монгол Улс доторх иргэдийн дэмжлэгийг авах шаардлагатай бус харин гадаад дахь монголчуудаас тодорхой хэмжээнд “хараат” болж эхэлжээ. Ингэхээр Засгийн газар, улс төрийн намууд гадаад дахь монголчуудтай харилцаа холбоогоо

бэхжүүлэхийг эрмэлзэж байгаа нь сайхан сэтгэлээс илүү, улс төрийн энгийн тооцоо, логик юм. Нөгөө талаас гадаад дахь монголчуудыг УИХ-ын сонгуульд оролцуулах замаар тэдний улс төрийн оролцоог “жинхэнэ” сонгогчийн хувьд хангах бололцоо өнөөг хүртэл хязгаарлагдмал байсан ба энэ нь зөвхөн зохион байгуулалтын төдийгүй, хууль зүйн бөгөөд санхүүгийн нэлээн ярвигтай асуудал юм.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын мэдээлснээр 2016 онд нийт 130 мянган монголчууд гадаадад байсан ба энэ нь 3 сая гаруй хүн амтай улсад том тоо.

2012 БА 2016 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИУД

Гадаад дахь монголчуудын идэвхтэн төлөөлөгчид 2000 оны эхэн үеэс л гадаад дахь монголчуудын улс төрийн оролцооны эрхийг хангуулах талаар ярьж, хэлж иржээ. 2008 оны УИХ-ын сонгуулийн дүнг мэдэгдсэний дараа хүний амь эрсэдсэн 7-р сарын 1-ний үйл явдал нь монголын улс төр-эдийн засгийн эрх баригчдыг илүү нээлттэй, олон талын оролцоог хангаж сонгууль зохион байгуулахад “хүргэсэн” юм¹.

Үүний үр дүнд гадаад дахь монголчууд 2012 онд анх удаа сонгуульд саналаа өгөх боломжтой болсон.

2012 оны УИХ-ын сонгуулийг холимог системээр явуулсан. УИХ-ын 76 суудлын 28-ыг нь улс төрийн намуудад пропорциональ системээр хуваарилсан тул энэ сонгуульд гадаад дахь монголчууд улс төрийн

нам, эвсэлд саналаа өгч оролцсон. Харин үлдсэн 48 суудлыг Монгол Улсын доторх 26 сонгуулийн тойрогт хэн хамгийн их сонгогчийн санал авсан нь сонгогдох замаар нэр дэвшигчдийг шууд өрсөлдүүлж хуваарилсан. Энэ 48 суудлыг хуваарилах сонгуулийн хэсэгт нь гадаад дахь монголчууд оролцоогүй.

Сонгуулийн хуулийг өөрчилсөнтэй холбогдуулан гадаад дахь монголчууд 2016 оны УИХ-ын сонгуульд оролцоогүй².

2016 оны УИХ-ын сонгуулиар сонгуулийн холимог системийг мажоритар систем болгож өөрчилсөн. УИХ-ын гишүүдийг улс орон даяарх тус бүр нэг мандаттай нийт 76 тойргоос шууд сонгосон.



► 2020 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛЬ

Энэ оны 6-р сард Монгол Ардын Нам улс орон даяар нэг л сонгуулийн тойрогтой байх байдлаар 2020 оны УИХ-ын сонгуулийг явуулах санал гаргасан. Энэхүү “нэг улс, нэг тойрог” тогтолцоонд гадаад дахь монголчууд саналаа өгч оролцох бололцоотой болно гэсэн үзэл бодлыг тойрсон албан бус хэлэлцүүлэг Хилийн Чанад дахь Монголчуудын Зөвлөлийн (ХЧМЗ) хүрээнд өрнөсөн.

ХЧМЗ нь гадаадад байгаа монгол судлаач, иргэдээр дамжуулан тэдний амьдарч буй улс нь гадаадад байгаа иргэдийнхээ сонгох эрхийг хэрхэн хангадаг талаарх асуулгыг бөглөхийг хүссэн. АНУ, Бельги, Герман, Солонгос, Финланд, Швед, Швейцар, Энэтхэг, Япон гэсэн улсуудын тухай мэдээллийг ХЧМЗ цуглуулсан. Энэ мэдээллээс сонгуулийн тойрог нь нэг эсвэл олон байхаас гадаад дахь иргэдийн сонгуулийн эрхийг хамааруулдаггүй юм байна гэдэг нь тодорхой болсон.

ҮЗЭЛ БОДОЛ

Улс орон даяар нэг тойрог болж УИХ-ын сонгуулийг зохион байгуулвал гадаад дахь монголчууд сонгуульд саналаа өгөх нь зохион байгуулалтын хувьд хялбар байх болно гэдгийг үгүйсгэж болохгүй. Сонгуулийн олон тойрогт тогтолцоонд сонгууль хийхэд

- Гадаад дахь иргэдийг аль сонгуулийн тойргийн харьяат гэж үзэх вэ?
- Сонгуулийн хуудсыг нь аль тойрогт, яаж буцаах вэ?
- Яаж тооллогод оруулах вэ? гэсэн нарийн зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулах хэрэгтэй болно.

Харин улс орон даяар нэг тойрог болж УИХ-ын сонгууль хийнэ гэдэг нь Ерөнхийлөгчийн сонгуультай ойролцоо зохион байгуулалтыг шаардана гэсэн үг.

Гадаад дахь монголчууд урьд нь 2013 ба 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгч байсан.

- Энд нэг тойрог, нэг улс нь ардчиллыг бэхжүүлэхэд тустай юу эсвэл хортой юу?
- Сонгогдсон УИХ-ын гишүүд нь орон нутгаас хамааралгүй болохоор жишээ нь уул уурхайн лиценз ба малын бэлчээрийн гэх мэт зөрчилдөөний үед асуудлыг аль аль талын эрх ашгийг харгалзаж шийдүүлэх бодит боломж нь ямар байх вэ? гэсэн бодлогын асуултыг нээлттэй үлдээе.

Зөвхөн зохион байгуулалтын талаас нь харахад л “нэг тойрог, нэг улсыг” зөвтгөх шалтгаан нь гадаад дахь монголчуудын оролцоог хангах явдал биш юм. Бодит байдал дээр гадаад дахь монголчуудын сонгуулийн жинхэнэ оролцоо өнгөрсөн сонгуулиудад тун муу байсан.

Гадаадад буй нийт 80 мянга орчим эрх бүхий сонгогчдоос сайндаа л 5 мянга орчим сонгогчид л сонгуульд оролцож байв³.

Хилийн чанад дахь монголчуудын сонгох эрхийг хангах боломжтой болно гэдэг нь угтаа социал орчинд “нэг тойрог, нэг улсыг” дэмжих дэмжлэгийг гадаад дахь “социал нөлөөлөгчдөөс” авах боломжийг эрэлхийлсэн зүйл байсан байж болох юм. Өнөөдрийн байдлаар гадаад дахь монголчуудын жинхэнэ хүч нь сонгогчийн хувьд бус, социал орчинд л байна.

2019 оны 7-р сар

¹ Пол Гуэрин, Монгол Улсад үзүүлсэн сонгуулийн туслалцааны сургамж 2008-2012 он, х. 4.

² OSCE/ODIHR Election Observation Mission Final Report, p. 6

³ 2012 оны УИХ сонгууль: 2279; 2013 оны Ерөнхийлөгчийн сонгууль: 4242; 2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль: 4767.



НИЙТЛЭЛ

Ц.БААСАНСҮРЭН

Сэтгүүлч

МОСКВА, ХОНГКОНГИЙН

ЭМЗЭГЛЭЛ маньд хамаатайн учир

Путиныг далайд шумбаж сүйрсэн хөлөгт хүндэтгэл үзүүлж явах зуур Москвад мянга гаруй жагсагчийг баривчилсан мэдээ дэлхийн хэвлэл мэдээллийнхний анхааралд байна. Харин хойд хөршийн голлох мэдээллийн сувгууд энэ үйл явдлыг мэдээлсэнгүй. Элдэв шоу, концерт цацсан шигээ өнжив. Ирэх намар болох хотын зөвлөлийн сонгуульд сөрөг хүчний нэр дэвшигчийг бүртгэлгүй хассан нь москвачуудыг жагсахад хүргэсэн юм. Ер нь хойд хөршийн сонгууль нэг том дохиурын дор болсоор ирсэн нь нуух юмгүй ил үнэн. Путин засаглалынх нь эхний жилүүдэд ийм аргаар эрх мэдэлд хүрсэн “хүнд гар”-уудаасаа салах гэж үйлээ үзэж байгаа тухай мэдээлэл дуулдаг л байдаг.

Москлагийн жагсаалтай зэрэгцсэн бас нэгэн жагсаал Хонгконгод өрнөж буй. Сарын өмнөөс сая орчим хүний эсэргүүцлээр эхэлсэн жагсаалын хүч өнөөг хүртэл суларсангүй. Хонгконгчуудын жагсаал өнөөдөр ч олон улсын анхааралд байна. Хятадын хууль тогтоомжийг зөрчсөн гэж сэжиглэгдэж буй хэнийг ч Хонгконгоос эх газрын Хятад руу шилжүүлэх агуулгатай хуулийн төслийг тэд эсэргүүцэж байгаа юм. Хуулийн төсөл батлагдвал авлига, эрүүгийн хэрэгтнүүдээс гадна хүний эрхийн төлөө тэмцэгчдийг ч хомроглон баривчилж Хятад руу шилжүүлэх эрсдэлтэй гэсэн болгоомжлолыг жагсагчид онцолж байгаа. Ямартай ч жагсагчдыг нулимс асгаруулах хий ашиглан тараасан гэж олон улсын мэдээллийн агентлагууд онцоллоо. Төчнөөн хүн бэртэж гэмтсэн гэх мэт нарийн ширийн мэдээлэл өнөөхөндөө алга. Эсэргүүцэл энэ янзаараа дарагдахгүй хүчээ авбал Бээжин хяналтаа чангатгаж магадгүй гэсэн таамаг шинжээчдэд байна.

Хонгконгчууд өмнө нь 2003 онд Улсын аюулгүй байдлын тухай хуулийг Бээжингийн сонирхолд нийцүүлэн батлах гэж байна хэмээн эсэргүүцэн жагссан түүхтэй. Тухайн үед жагсагчид “Хэрвээ энэ хууль батлагдвал Хятадын эрх баригчдын зүгээс

автономит нутаг дэвсгэрийн дотоод хэрэгт тавих хяналт нэмэгдэж, ардчилсан эрх, иргэдийн эрх чөлөө боомилгодоно” гэцгээж байв. Эсэргүүцлийн жагсаалаас болж тухайн үед яригдаж явсан хуулийн төслийн хэлэлцүүлэг тодорхойгүй хугацаагаар хойшилж байлаа. Хонгконгчуудын бас нэг жагсаалыг онцлохгүй орхиж болохгүй. Оюутнууд нь таван жилийн өмнө сонгуулийн системийг ардчилсан болгохыг шаардаж, 79 өдрийн турш эсэргүүцлээ илэрхийлсэн удаатай. Тэр жилийн оюутнуудын эсэргүүцэл дэлхийн түүхэнд “Шүхэрт хөдөлгөөн” гэдэг нэрээр үлдсэн юм.


Тоймлоод харвал урд, хойд хөршийн иргэд ардчилал, эрх чөлөө, шударга сонгуулийн төлөө жагсаал зохион байгуулж, удирдагчид нь иргэдийнхээ жагсаалыг албадан тарааж, мянга давсан хүнийг баривчилж хорьж байна. Бусад улсаас илүү бидэнд хамаатай үйл явдлууд. Бүр хачин их хамаатай үзэгдэл. АНУ-д төвтэй “Фрийдом хаус”-ын “Эрх чөлөөний газрын зураг” дээр манайх хавь ойрынхоо улсуудаас цор ганцаараа ногооноор тэмдэглэгддэг. Дэлхий даяараа Азийн монголыг “Ардчиллын баян бүрд” гэдэг нь цаанаа ийм учиртай. Тус байгууллагынхан сүүлийн арваад жилийн турш эрх чөлөө нь хумигдах улс орнуудын тоо нэмэгдсээр ирснийг хоёр жилийн өмнө онцолж байлаа. “Фрийдом хаус” иргэний, улс төрийн эрхийн судалгааг жил бүр явуулж, дэлхийн улс орнуудыг 1-7 хүртэл оноогоор дүгнэдэг. Ингээд эрх чөлөөтэй, хагас эрх чөлөөтэй, эрх чөлөөгүй гэсэн гурван ангиллаар ардчиллыг хэмжчихдэг. Тэдний судалгаагаар хуучин соц лагерийн орнуудаас Төв, Зүүн Европын Чех, Польш, Монгол л эрх чөлөөтэй гэсэн ангилалд багтдаг юм. Бүр тодруулж хэлбэл Европт орших өнөө хоёрыг эс тооцвол тивдээ, бүсдээ бид эрх чөлөөтэй, ардчилалтай цор ганц улс. Зүүн хойд Азиасаа гэж яривал Өмнөд Солонгос, Япон л “ногоон арал”. Өөрөөр хэлбэл хоёр хөршөөсөө ялгарах бидний маш том онцлог, давуу тал энэ. Бид ардчилалтай, зах зээлийн эдийн засагтай, эрх чөлөөнийхөө хувьд “ногоон арал”.



■ FREE

■ PARTLY FREE

■ NOT FREE



- Гэхдээ нөгөө талаас нь харвал ардчилал их эмзэг. Тэр дундаа манайх шиг хавь ойрдоо ганцаараа эрх чөлөөгөө тунхагласан жижиг улсын ардчилал бүр эмзэг. Хөршүүд нь дэлхийн их гүрнүүд гэсэн өнцгөөс ажвал хээрийн шувууны өндөг шиг сүүдэр тусгахгүй хамгаалах учиртай эрхэм нандин зүйл. Манайх шиг эрх чөлөөг оройдоо залсан, чөлөөт эдийн засагтай дажгүй хөгжиж яваад уруудсан улсын жишээ цэнхэр гаригт цөөнгүй. Улиг болтол давтагддаг наад захын жишээ гэхэд л Венесуэл. Газрын тосны их нөөцтэй энэ улс цагтаа дэлхийн том эдийн засгуудын нэг байсан ч хүчтэй ганц удирдагчийн олон жилийн хаанчлал энэ улсыг үгүй хийчихсэн. Өнөө удирдагч нь гадаадын хөрөнгө оруулагчдыг хөөж, хөрөнгө оруулсан төсөл бизнесийг нь хурааж авч, иргэддээ орон сууц тарааж хэсэгтээ бужигнуулсан. Орон сууцтай, зүгээр сууж байгаад дажгүй амьдрах бололцоотой болсон нийт олонх Мадурог үг хэлэх болгонд л алга нижигнүүлж явсан даажинтай үнэн Венесуэлийн өнгөрсөн түүхэнд бий. Одоо тэнд инфляци өчнөөн тэгтэй тоогоор хэмжигдэж, иргэд нь даржин аж төрж, арай дажгүй сэхээлэг хэсэг нь эх орноосоо дүрвэж байна.

ОХУ ч ялгаагүй Путин засаглалаа тогтоож тэрбумтнуудаа шоронд хийж, төрд бүхнийг гэсэн уриа хүчээ авч эхэлснээс хойш байдал эвгүйдсэн. Өнөөдөр Оросын эдийн засаг хэцүүхэн байгааг учир мэдэх эдийн засагчид сануулаад, онцлоод эхэлчихсэн. Ямар сайндаа л Москвачуудыг талхаар хангадаг том үйлдвэрийнх нь ажилчид хэдэн сар цалингаа аваагүй гэж ажил хаяж өлсгөлөн зарлахаар. Москвачуудыг талхаар нь таслаж байж үйлдвэрийн ажилчид цалинтайгаа залгасан нь ердөө саяхны үйл явдал. Хойд хөршийн эдийн засаг хэцүүдэж, рублийн

ханш шал арчих болсон шалтгааныг холоос хайх шаардлагагүй. Бизнес нь төрийн оролцоо хүчээ авч, төр бүхнийг чадагч супермэн болсны л гэм. Урд хөршийн тухайд дэлхийн том эдийн засгийн нэг ч сүүлийн үед тод анзаарагдах болсон нэг үзэгдэл нь хөрөнгө оруулагчдыг дайжихад хүргэж байгаа. Төрийн оролцоотой хүчирхэг компаниудын давамгайлал энэ улсын эдийн засагт муугаар нөлөөлж эхэлсэн гэсэн дүгнэлтийг учих мэдэх улс хэлээд эхэлчихлээ. Төрийн компаниудаа нэгтгэлээ, томрууллаа, төрийн өмчийн ийм тийм компани байгууллаа гэсэн агуулгатай мэдээлэл давтамжтай дуулдах болсныг уншигч та ч анзаарсан байх.

Эрчээ алдахгүй яваа том эдийн засагтай улсуудын түүхийг сөхөхөд зах зээлээ жамаар нь хөгжүүлсэн орнууд л гялалзаж яваа анзаарагддаг. Улс төрчид нь төрд бүхнийг, хүчирхэг төр гэж цээжээ дэлдэж, баялаг бүтээгч, том компаниудаа адлаж, өнөөхийг нь иргэд нь олонхоороо дэмжээд алга ташаад эхлэхээр алсдаа байдал бишдэж байгааг Венесуэл, ОХУ зэрэг улсаас харчихаж болно. Манайд ч иргэдийнхээ эрх, бизнесийн эрх чөлөөг уландаа гишгэсэн энэ улсуудын эхэн үеийн попрол анзаарагдаад удаж байгаа. Манай эрх баригчид том төсөл эхлүүлсэн улс төрчдийг толгой дараалан баривчилж, томоохон компанийн захирлуудын гарт гав зүүж, үндэсний компанийнхаа хөрөнгийг хураана гэсэн сүржин мэдэгдэл хийж, гадны ганц том хөрөнгө оруулагчаа байсхийгээд дуэлд дуудсан шигээ аж төрцгөөж байна, өнөөхөндөө. Хамгийн эмзэглэмээр нь удирдагчдын энэ үйлдэлд нийт олонх алга ташицгааж байна. Анзаарч харахаар л өнцөг.



Ц.БАТБОЛД

Хөгжлийн эдийн засагч (PhD), олон улсын хуульч
бөгөөд АНУ-д мэргэжлээрээ ажиллаж байна.

НИЙТЛЭЛ

ҮНДСЭН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ ЮУНД ТӨВЛӨРӨХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

1992 оны Үндсэн хууль бол Монгол улсыг ардчилал, зах зээлд шилжүүлэх эхлэлийг тавьсан завсрын шинжтэй хууль бөгөөд түүнийг өөрчлөх зорилго нь тэр шилжилтийг гүйцээж, технологийн хурдыг даган эрс өөрчлөгдөх өнөөгийн ертөнцөд Монгол улсын цаашдын хөгжлийн аятай нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Гэвч санал боловсруулах, хэлэлцүүлэх явцыг харахад мэргэжлийн удирдлага, одоо ирээдүйн бодит анализ гэхээсээ, шилжилтийн “ороо бусгаа” үеийн “будлиу” онол практикт хөтлөгдсөн, олон талаар хойш татсан ашиг сонирхлын зөвшилцөл, эцсийн дүнд урагшлалт биш бүр ухралт болж мэдмээр байна. Ялангуяа Үндсэн хуульд засаглалын үүсэл хөгжлийн чиг хандлага болсон төрийн хүчирхийллээс хувь хүний эрх чөлөөг хамгаалж, “Rule of law” буюу хуулийн засаглалыг тогтоох гол зорилт үндсэндээ орхигдож, Үндсэн хуульд хамааралгүй, зах зээлийн зарчим ба засаглалын хуваарийг бусниулсан популист шинжтэй олон заалт орж ирэх шинжтэй.

Анх 1215 онд Английн хаан бие даасан шүүхийн шийдвэргүйгээр хүнийг баривчлах, шоронд хийх, эрхийг нь зөрчих, эд хөрөнгийг нь хураахыг хориглосон Магна Картад гарын үсэг зурснаас эхлээд Англи Америкийн Үндсэн хуулийн салшгүй хэсэг “Bill of Rights”, хөгжингүй бусад орны Үндсэн хууль, олон улсын хүний эрхийн конвенцуудад баталгаажсан түгээмэл зарчмуудыг социалист байсан орнууд де-юре хүлээн зөвшөөрсөн. Гэсэн ч угаас хаант төр шиг дээрээсээ захиргаадсан удирдлагатай, иргэд нь хамжлагат ард шиг эрхээ хязгаарлуулсныхаа хариуд эзэн төрийн алба хангамжид дулдуйдан амьдарч байсан тул тийм хууль зүй нь ч, түүнийг сахиулах хараат бус шүүхийн тогтолцоо нь ч төрж бойжсонгүй. Үүний улмаас төрийн эрхэнд гарсан удирдагчид нь хууль хүчний байгууллагыг ашиглан өрсөлдөгч шүүмжлэгчдээ намнадаг, дийлдэхээрээ өөрөө намнуулдаг, тэгэхгүйн тулд ямар нэг хэмжээгээр дарангуйлалд шилждэг гэм биш жамтай байв. Энэ зан өнөөдөр ч үргэлжилж байна.

Монголд баригдаж хоригдсон бизнесмэнүүдийнхээ эрхийг хамгаалж шүүмжилж байсан гадаад ертөнц

өнөөдөр эрхэлсэн ажил үүрэг, дүрэм журмынхаа дагуу ил тод гаргасан шийдвэрийнх нь төлөө Засгийн газрынхаа тэргүүн, сайд нарт гэмт хэрэг үүсгээд байгааг гайхаад байна. Уг нь хүнийг гэмт хэрэгт татахад “nulla poena sine lege” зарчмын дагуу хуульд нэн тодорхой зааж хориглосон гэмт хэргээс гадна, “actus reus” буюу тэр зүйл ангид нь яв цав тохирсон гэмт үйлдэл, мөн “mens rea” буюу бурууг нь мэдсээр байж тэр гэмт хэргийг үйлдэх хүсэл зоригтой байсныг нь тогтоосон, учруулсан хор хохирол нь тэр хүсэл зоригтой нь авцалдсан байх ёстой байдаг. Аль ч оронд хамгийн гол нь хүн шүүхээр шийтгэгдтэл нь буруугүй гэж үзэж, Үндсэн хуулиар олгогдсон халдашгүй эрхүүдийг нь эдлүүлж, өөрийгөө шүүхийн өмнө бүрэн хамгаалах бололцоо олгохыг чухалчилдаг.

Хэдийгээр манайх Оросоор дамжсан Герман Францын нөлөөтэй эх газрын эрх зүйн уламжлалтай боловч, даяаршлалыг даган улам ойртон нэгдэж байгаа хуулийн засаглалын орчин үеийн жишээ болгож АНУ-ын практикаас сонирхууя.



- АНУ-д хүнийг гэмт хэрэг өдүүлсэн “probable cause” буюу хангалттай шалтгаангүйгээр баривчлахыг хориглодог ба зөвхөн шүүхийн “warrant” зөвшөөрлөөр, тийм бололцоогүй байсан бол 48 цагийн дотор шүүхээр шалгуулсан шийдвэрээр баривчилж болдог. Баривчлахдаа өөрийнхөө эсрэг утгатай мэдүүлэг өгөхөөс татгалзах, өмгөөлөгч авах эрхтэйг нь мэдэгдэж, төлбөрийн чадваргүй хүнд улсаас өмгөөлөгч олгох ёстой байдаг. Энэ нь хуурч буюу дарамталж хэрэг хүлээлгэхээс сэргийлдэг гэж үздэг тул ингээгүй бол баривчилгаа, мэдүүлэг өгөхөөс татгалзсаныг нь буруутгахад ашигласан гэж үзвэл хэрэг хүчингүй болдог.
- Ер нь хэргийг илрүүлэх гэж баривчлахыг хориглодог ба шаардлагатай бол батлан даалт буюу санхүүгийн дэнчин “бонд” тавиулдаг. Энэ нь тэр хүн шоронгоос гадуур байж өөрийгөө ялаас хамгаалах ажлыг зохион байгуулж хөөцөлдөх бололцоо олгохтой холбоотой юм. Хэрэгт нь ахадсан хэт өндөр бонд шаардахыг мөн Үндсэн хуулиар хориглож, зөвхөн баривчлахгүй бол зугтаж алга болох буюу бусдад аюул учруулах өндөр магадлалтай үед л бонд тавих эрхийг шүүхээс хэрэгсэхгүй болгож болдог.
- Үндсэн хуулийн 6-р нэмэлтэд зааснаар хүн бүр нээлттэй шүүхээр “түргэн хугацаанд” хэргээ шийдүүлэх эрхтэй бөгөөд “Speedy Trial Act” хуульд зааснаар баривчилснаас 30 хоногийн дотор багтаан албан ёсоор ял тулгаж, 70-аас илүүгүй хоногийн дотор шүүхээр хэлэлцүүлэх ёстой байна. Хэрэв яллагдагчийн хүсэлт, буруугаар биш шалтгаанаар шүүх хурал удааширч хойшлогдсон бол учирсан материалын болон сэтгэл санааны хохирлыг шүүхийн шийдвэрт харгалзах болдог.
- Шүүхийн “pre-liminary” буюу анхны хурал нь чухамдаа тулгасан ял хэр үндэстэйг хараат бус шүүгчээр шалгуулж нягтлуулахад чиглэдэг ба шаардлагатай бол шүүгч ялын төлөвлөгөөг өөрчилдөг. Хуулийн соёл өндөр АНУ-д ч нийт хэргийн 5-10 хувь нь энэ шатанд хэрэгсэхгүй болдог байна. Баривчлагдсан хүн тулгаж байгаа ял нотолгоотой танилцаж, өөрийнх нь эсрэг гэрчлэгчтэй нүүрэлдэх, өмгөөлөгчийнхөө тусламжтайгаар байцаах, өөрийгөө хамгаалахад хэрэгтэй гэрчүүдийг оролцуулах эрхтэй. Иргэний хэрэгт нотолгоо баримт аль илүүтэй тал дийлдэг бол эрүүгийн хэрэгт яллагч гэмт үйлдлийг нь “clear and convincing” буюу хөдлөшгүй баримттайгаар “beyond reasonable doubt” буюу эргэлзэх аргагүй нотлох ёстой ба өмгөөлөгч бол тийм түвшинд нотлож чадаагүйг нь батлаж чадвал л хэрэг хүчингүй болдог. Ялангуяа шүүгчид буюу гэрчид нөлөө үзүүлсэн байвал шийтгэл хүчингүй болдог “Webb v Texas” гэдэг хүчтэй прецедент үйлчилдэг.

Яг өнөөдөр (7/24) Ерөнхийлөгч Трамп сонгуульд ялахдаа Оростой хуйвалдсан эсэхийг шалгасан Р.Муллер конгрессд тайлагнаж байна. Тэрээр Оросын албад Хилларигийн эсрэг Трампыг дэмжих зорилгоор америкчуудын нэрээр хуурамч данс нээж хутган үймүүлэх өргөн хүрээтэй ажиллагаа явуулсан нь тодорхой боловч, Трампынхан идэвхтэй хамтарч ажилласан нь батлагдахгүй байгааг дурдаад, Ерөнхийлөгч биечлэн байцаалт өгөхөөс зугтаж, бичгээр өгсөн мэдүүлэгтээ ихэнхийг нь санахгүй байна гэж хариулаад зарим асуултыг огт хариулаагүй нь түүний гэмт хүсэл зоригийг тогтооход саад болсныг тэмдэглэв. Гэхдээ өөрийг нь шалгаж байгаа хуулийн ажилтнуудыг гүтгэх, дарамтлах, ажлаас нь халах, гэрчид мөнгө өгч буюу өршөөл үзүүлэх горьдлого төрүүлэх, худлаа мэдүүлэг өгөхийг шаардах зэргээр нөлөөлөхийг оролдсоноор “obstruction of justice” гэдэг гэмт хэргийн олон нотолгоо бүрдсэн учир Сенат дахь намынх нь олонх шүүхэд татагдахаас хамгаалсан ч, ажлаа өгснийхөө дараа хэд хэдэн гэмт хэрэгт татагдах үндэстэйг батлав.

Шүүх болон яллагчийн хүчирхийллээс яллагдагчийг хамгаалах маш эртний үүсэлтэй бас нэг хэлбэр нь мөн Үндсэн хуулиар баталгаажсан журигээр хэргээ таслуулах эрх юм. Ялангуяа Трампын холбогдсон зарим хэрэг шиг хүнд төрлийн гэмт хэрэгт аль ч талыг барихгүй 23 хүнээс бүрдсэн Их жури хэргийн материал нотолгоотой танилцаж шүүхэд шилжүүлэх эсэхийг олонхын саналаар шийддэг бол 6 буюу 12 хүнтэй бага жури шүүх хурлын бүх ажиллагаанд оролцож зөвхөн тэд яллагдагч буруутай гэж санал нэгтэй үзсэн тохиолдолд л шүүгч ял ногдуулдаг. Яллагдагчийн эсрэг байр суурьтай хүнийг журид оруулахгүйн зэрэгцээ, шүүхийн хараат бус байдалд олон нийт, хэвлэл мэдээлэл дарамт шахалт үзүүлэхээс сэргийлэх зорилготой баримтжуулалт нотолгооны хатуу дүрмүүд байдаг.

Сүүлийн үед эрх зүйн өөр уламжлалтай Латин америкийн орнууд, Япон, Солонгос болон Орост бас жури ашиглах болсон нь эх газрын системд “inquisitorial” буюу хэргийг илрүүлж шийтгэх үүрэгтэй шүүгч яллагчийн нөлөөнд орох гээд байдагтай холбоотой байна. Мөн Ерөнхийлөгч, Парламент, Засгийн газрын шийдвэр (үндсэн) хуульд нийцэж байгаа эсэхийг шүүх мэдэж тогтоодог “judicial review” зарчим Европын орнуудад дэлгэрч байна.

ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ

► Аливаа албан тушаалтан шүүхийн ажиллагаа, шийдвэрийг чиглүүлсэн мэдэгдэл, үйл ажиллагаа хийх нь өөрөө гэмт хэрэг болдгоос гадна тийм нөлөөнд орсон шүүгч мэргэжлийн стандартаа зөрчсөн хэрэгт ордог. Хуульчдын мэргэжил нь төрөөс тусдаа өөрөө өөрийгөө удирдах зохион байгуулалттай байдаг. Энэ нь төрийн зүгээс эрх мэдлээ хэтрүүлэн ашиглахаас иргэдийг хамгаалах чадварыг шүүх болон хуульчдад бодитой олгох баталгаа болдог гэж үздэг. Жишээ нь Америкийн “Бар Ассоциаци” хуульчдаас шалгалт авч ажиллах эрх олгох ба “model rules professional conduct” буюу ажилдаа баримтлах мэргэжлийн стандартыг тогтоодог. Энэ дүрмийн

- 3.8-д хэрвээ яллагдагч тухайн гэмт хэрэг үйлдээгүй нь нотлогдож байвал яллагч өөрөө ялыг өөрчлөх үүрэгтэй.
- 5.4-т хуульч мэргэжлийн шийдвэр гаргахдаа бусад хүний заавар, зохицуулалтыг хүлээж авч болохгүй.
- 8.3-т хуульчид өөр хуульч буюу шүүгч энэхүү дүрмийг зөрчсөнийг мэдвэл зохих удирдлагад мэдэгдэх үүрэгтэй.
- 8.4-т энэхүү дүрмийг зөрчсөн шүүгч буюу шүүхийн ажилтанд туслаж болохгүйг заажээ.

Бид Үндсэн хуулийн өөрчлөлт хийхдээ хуулийн засаглалын орчин үеийн нийтлэг стандартуудыг нэвтрүүлж, тэднийг хамгаалах өндөр мэргэжлийн хараат бус шүүхийн тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй байна. Тэгж байж нийгэмд шударга ёс тогтож, хүмүүсийн бухимдал цөхрөл тайлагдаж, аливаа асуудлыг хоосон улс төржилгүй, прагматикаар хамтран шийдвэрлэдэг болно.

Энэ талын гол онолч Ж.Роулз (John Rawls, A Theory of Justice) хүмүүс ямар хүйс, ухаан боловсрол, ажил, орлого, өвчин зовлонтой болохоо төсөөлж чадахгүй тохиолдолд нийгэм ямар байгаасай гэж хүсэхээр шударга ёс тодорхойлогддог гээд

1. Хүн бүр аль болох тэгш өргөн эрх чөлөөтэй байх
2. Нийгэмд эзлэх байр, ажил орлогын боломж бүгдэд нээлттэй байх
3. Харилцан адилгүй чадвартайн улмаас орлогын ялгаа ихсэхэд хамгийн ядуу доод давхаргын амьжиргаа доордохгүй дээрдэж байвал шударга ёс хангагддаг гэж нотолжээ.

Харин хууль хүчний систем улс төржилт, авлигад дийлдвэл нийгэм эрүүлжих эцсийн найдвар алдагдаж, цаашид улам хэмхэлдэн бүр илүү хямралд орох аюултай юм. Ялангуяа мэдээллийн технологи, гадны нөлөөн доорх нийгмийн сүлжээ хүн бүрт микрофон өгч, хүмүүс гашуун үнэнийг мэдэж, хэцүү ч гэсэн бодитой шийдвэрийг хайхаасаа илүү, өөртөө таалагдсан мэдээлэлд итгэж, өөрөөсөө илүү мэдлэг чадварт атаархаж үгүйсгэх болсон өнөөгийн “echo chamber” ертөнцөд шууд ардчилал нь популист улс төрчид, луйварчин мэдлэгтнүүд буюу хамгийн болохгүй нөхдүүд төрийн эрхэнд гарах “kakistocracy” хэрэгсэл болж байна. Орчин үед зонхилж байсан социал демократ үзэл эцсийн логик нь Сталин Гитлерийн дэглэм болсон Марксизм ба үндсэрхэг Nativism-аар солигдох аюул тулгарч байгааг П.Коллер “Капитализмын ирээдүй” (Paul Collier, The Future of Capitalism) номондоо (203-р хуудас) анхааруулжээ. Ерөнхийлөгчийн болон парламентын засаглалын үлгэр гэдэг байсан АНУ, Англид болж байгаа үйл явдал үүнийг нотлож байна. Харин парламентаа орон тооны бус болгож улс төрчдийн хэт идэвхийг хязгаарласан Швейцарь, пропорциональ системтэй учир олон намын эвсэл засагладаг Голланд, Норвеги, Швед зэрэг орон ийм хямралд бага нэрвэгдэж байна.

Зах зээлийн социализмын онолыг үндэслэгч С.Милл (John Stuart Mill) тийм энэрэнгүй нийгмийг байгуулах үндэс нь өмчийн эрхийг бүрэн хангах замаар үйлдвэрлэл, татварын эх үүсвэрийг өсгөх явдал юм гээд татвар төлдөггүй төрөөс тэтгүүлэгч зонхилсон нөхцөлд бүх нийтийн ардчилал “tyranny of the majority” буюу хуулийн засаглалын эсрэг популизм ундраах аюултайг анхааруулж байв. Ийм нөхцөлд “clergy” буюу шинжлэх ухаанч хар лам нар, өнөөгийнхөөр бол мэргэжилтнүүд нийгмийг удирдах дүрмийг боловсруулах нь зүйтэй гэжээ.

Үндсэн хуульд оруулахаар залуу хуульчид дэвшүүлж байгаа саналууд, Ерөнхий сайд асан Содном гуайн санал хамгийн хэрэгтэй мэт санагдаж байна. Үнэндээ Монголд ардчилал зах зээлд шилжиж дуусаагүйн бэрхшээлүүдээ төрийн хүч, хуулийн өөрчлөлтөөр шийдэх гэнэн хүсэл давамгайлж, түүнд нь дөрөөлсөн улс төржилт, авлига, хуулийн завхрал хөгжлийн тушаа болж байна. Ийм нөхцөлд төсвийн сахилга, төрийн ажлын үр дүнгийн тооцоог сайжруулах, улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт нэвтрүүлэх зэрэг удирдлагын бүх түвшин, эрх мэдэлд таарсан хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх нь Үндсэн хууль өөрчлөхөөс чухал.

2019 оны 7-р сар



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.07.28-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

АВЛИГЫН НЭГ ХЭРЭГ ШИЙДЭГДЭВ, БУСАД НЬ?

Үйл явдлын товч:

Эрчим хүчний сайд асан М.Сономпилийг шүүхээс 4 жилийн хорих ял сонссон тухай мэдээг та твиттер хуудсаараа “Авлига авсан хэргээр анх удаа л шүүхийн шийдвэр гарч байна. Бусад нь шүүх хурал нь хойшилсоор байгаад хөөн хэлэлцэх хугацаа нь дуусаад хэрэгсэхгүй болдог” гэж мэдээлсэн байсан. Тэгэхээр нийтийн хөрөнгөд хохирол учруулсан буюу авлигын хэргүүдийн тухай ярьа.



Дүгнэлт тайлбар:

Ер нь манайд авлигын хэргийн улмаас хохирсон хохирлын хэмжээг тооцсон статистик ямар үзүүлэлттэй байна?

Эрчим хүчний сайд асан М.Сономпилийн хувьд: Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2019 оны 7-р сарын 24-ний өдрийн шүүх хуралдаанаар: Нийслэлийн Прокурорын газраас

Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд асан М.Сономпилийг 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т заасан "...албан тушаалын эрх мэдлийг урвуулан ашиглаж албаны эрх ашгийн эсрэг хийх ёсгүй үйлдлийг хийж Монгол Улсын эрх ашиг, сонирхолд онц их хэмжээний хохирол учруулсан" гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д (гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй) заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд асан М.Сономпилийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлийн 4-т заасан "...нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс хийх ёсгүй үйлдлийг хийж, бусдаар дамжуулан хахууль авсан..." гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, 4 жилийн хорих ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлж, гэмт хэрэг үйлдэж олсон 266 сая төгрөгийг улсын орлого болгохоор зааж, түүнд авсан хувийн баталгаа гаргах болон Монгол Улсын хилээр гарахыг хязгаарласан хязгаарлалт тогтоосон таслан сэргийлэх арга хэмжээнүүдийг өөрчилж, цагдан хорьж шийдвэрлэсэн.

Ер нь авлига онц их ашигтай бизнес болчихсон нь Үндэсний статистикийн хорооноос гаргасан тоон мэдээллээр батлагдаж байна. 2011 болон 2018 оны тоон мэдээллийг харахад авлигын улмаас учирсан хохирлын зөвхөн 2-4 хувийг нь л нөхөн төлүүлсэн байна. Гол нь бид алдсан мөнгөө буцаан авах ёстой болохоос хэн нэг авлигач хоригдож, баригдах нь халуун ч биш, хүйтэн ч биш.

Авлига	2011	2018
Учирсан хохирол бүгд	22.7	663.2
Нөхөн төлүүлэлт	1.1	17.5

Хэмжих нэгж: Тэрбум.төг

Авлигын хэргийн шийдвэрлэлтийн статистик үзүүлэлт ямар байна?

Статистик үзүүлэлт	Авлига	2011	2018
Хэрэг	Тайлант хугацаанд шалгаж шийдвэрлэвэл зохих-Бүгд	144	1,138
	Мөрдөн байцаалт явуулсан-Бүгд	110	299
	Хэрэгсэхгүй болгосон	35	4
	Мөрдөн байцаалтын үндсэн хугацаанд шийдвэрлэсэн-Бүгд	50	1,068

Статистик үзүүлэлт	Авлига	2011	2018
Хүн	Тайлант хугацаанд шалгаж шийдвэрлэвэл зохих-Бүгд	324	1,224
	Мөрдөн байцаалт явуулсан-Бүгд	250	476
	Хэрэгсэхгүй болгосон	51	4
	Мөрдөн байцаалтын үндсэн хугацаанд шийдвэрлэсэн-Бүгд	99	393

Мөн Хурц нарын хэрэг, Эрдэнэт үйлдвэрийн 49 хувьтай холбоотой хэргүүдийн хувьд ямар шинэ мэдээлэл байна?

Б.Хурц нарыг шүүх хурал 8-р сарын 12-ны өдөр хүртэл хойшилсон. Эрдэнэтийн хувьд "АТГ болон ЦЕГ-аас 49 хувийн асуудлыг мөнгө угаах гэмт хэргийн шинжтэй үйлдэл байж болзошгүй гэж үзэж, "Эрдэнэт үйлдвэр"-тэй холбоотой зарим нэг аж ахуйн нэгжийн гүйлгээг шалгах хэрэгтэй тул Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнээр ахлуулсан ажлын хэсэг "Эрдэнэт үйлдвэр"-т ажиллаж, 8 өрөөг битүүмжлэн, "Эрдэнэт үйлдвэр"-ийн Тэргүүн дэд захирал, Эдийн засгийн асуудал хариуцсан орлогч дарга болон Хуулийн хэлтэс, Санхүүгийн хэлтэс, Хангамжийн хэлтэс, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн. 3-р сарын 05-нд Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газраас Худалдаа хөгжлийн банкны ТУЗ-ийн

дарга Д.Эрдэнэбилэг, Гүйцэтгэх захирал О.Орхон, "Монголын зэс" корпорацийн Гүйцэтгэх захирал Ц.Пүрэвтүвшин нарыг саатуулан байцаалт авсан. Улмаар Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс дээрх гурван хүнийг үргэлжлүүлэн хорих шаардлагагүй гэж үзэж, суллах шийдвэр гаргасан. Ингээд 49 хувьтай холбоотой хүмүүсийг гадуур шалгаж байгаа. Эдгээр хэрэг иймэрхүү л байдалтай байгаа. Сонгууль хүртэл шийдэгдэхгүй дээ.

Ер нь Монгол улс одоогийн арга барилаараа авлигатай тэмцэхэд дэндүү хангалтгүй юм биш үү. Яаж авлигатай тэмцэх нь үр дүнтэй вэ, бусад үлсуудын туршилагаас үзэхэд?

Авлигатай тэмцэх чадвар одоогийн төр засагт байхгүй. Учир нь тэд харилцан хамааралтай, харилцан барьцаалсан улс төрийн хүчнүүд. Үндсэн хууль өөрчилнө гэсээр сонгуульд хүрэх байх.

"ИРЭЭДҮЙН ӨВ САН КОРПОРАЦИ" ХХК БАЙГУУЛАВ

Үйл явдлын товч

Энэ оны 2-р сарыг хүртэл Монгол улс Засгийн газрын харьяа 29 тусгай сантай байсан. Харин ЖДҮ-ийн хэргээс болоод тэдгээр сангуудад шалгалт хийж 7-г нь татан буулгаж, 3-г нь нэгтгэж 20 тусгай сантай үлдсэн. Эдгээр 20 тусгай сангийн нэг Ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх "Ирээдүйн өв сан корпораци" ХХК-ийг энэ долоо хоногт байгуулчихлаа.

Дүгнэлт тайлбар

Түр хэрэглээд дуусчих байгалийн баялагтай орнуудын хувьд баялагаас олох орлогыг жигд зохистой хуваарилан хэрэглэж, баялаг дууссан хойно ч орлого үргэлжлэх хуримтлал бий болгох нь төсвийн бодлогын гол зорилт байдаг. Үүний тулд "Natural resources fund" буюу Байгалийн баялагийн сан байгуулдаг ба Чилийн Тогтворжуулалтын сан, Норвегийн Тэтгэмжийн сан, Кувейтийн Ирээдүйн сан, Оросын Нефтийн сан, Ботсваны Пула сан зэрэг нь түүний жишээ. "Зах зээлийн эдийн засагт хүмүүс хэрэглээгээ харьцангуй баталгаатай орлогын түвшинд байлгаж, түр зуурын орлогыг хэрэглэхгүй хадгалах замаар хөрөнгийнхөө түвшинг буюу амьжиргааныхаа суурийг бууруулахгүй байхыг

эрмэлзэж байдаг" тухай Нобелийн шагналт М.Фридманы "Permanent income hypothesis" (PIH) буюу "Байнгын орлогын төсөөлөл" гэдэг онол байдаг. Энэ нь "хүн ажил хийж олох орлогоо амьдралынхаа туршид жигд хуваарилахын тулд хүүхэд залуудаа, бусдаар тэтгүүлж ажиллаж байхдаа хадгалж хурааснаасаа хөгшрөхдөө хэрэглэдэг тухай" Нобелийн шагналт Ф.Модиглианийн "Амьдралын мөчлөг" онолтой бас тохирдог, эдийн засгийн тоо баримтаар сайн нотлогдсон зүй тогтол.

ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ хуульд зааснаар нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор Ирээдүйн өв санг байгуулсан гэж заасан байгаа. Сангийн орлого нь төсөвт байгалийн баялагийн ашиглалтаас орж буй мөнгөнөөс хуульд заасан хэмжээгээр авна. Одоогоор Ирээдүйн өв санд 213 тэрбум төгрөг хуримтлагдаад байгаа гэж мэдээлж байна лээ.

Энэ төрийн өмчит компани зөвхөн хуримтлуулаад суух учраас арай ч алдагдалтай ажиллахгүй байлгүй дээ.

Та "Дефакто Газет" цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отронсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com